



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/1080

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс  
хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 91 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 8,922,722.05 (найман сая есөн зуун хорин хоёр мянга долоон зуун хорин хоёр төгрөг таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 449 дүгээр ус түгээх байрыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасагдаж буй барилгыг буулгах ажлыг зохион байгуулахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-т даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



1110204659



Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
09 дугаар сарын 15-ны өдрийн  
захирамжийн  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Ус түгээх 449	Баянзүрх дүүрэг, 35-р хороо, Улиастай Баатархайрханы задгай	11	8,922,722.05	3,582,608.14	5,340,113.91
Дүн				8,922,722.05	3,582,608.14	5,340,113.91